

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Шүүхийн Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/119/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор хот 2026 оны 02 дугаар сарын 24</p> <p>2026</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат</p> <p>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: М.Алтантуяа</p> <p>Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Энхзул</p> <p>Утас: 99009293 Цахим хаяг: enkhzulg@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.МӨНГӨНЦЭЦЭГ ТАНАА

2026.02.24 № 2/58

танай _____-ны № _____-т

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

64260501??

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-
албан тоот.docx

Тайлант онд ажилчидтай холбогдсон нийгмийн даатгалын шимтгэлийн 8,364.7 мянга, ХАОАТ-ын 6,696.7 мянга, урсгал засварын материалын 803.4 мянга, бичиг хэргийн материалын 2,699.7 мянган төгрөгийн нийт 21,946.9 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн нь төсвийн зарцуулах эрх нээгдээгүйгээс шалтгаалсан үүссэн өр төлбөр байна.

Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Рашаант 10 дугаар багийн Гурван бүсийн өргөн чөлөө-3 304 хаягт байрлах 6409009334 нэгж талбарын дугаар бүхий 852 м.кв талбайн хэмжээтэй газрыг 2018 онд Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогоор дахин үнэлгээнд оруулж иргэний эзэмшлийн 239 м.кв газрыг хэмжилтэд оруулж хийснээс 1091 м.кв талбайн хэмжээтэй үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна. Зөрүүтэй тусгасан газрын мэдээллийг аймгийн ГХБХБГ-аас мэдэгдэж аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/618 тоот захирамжаар 852 м.кв хэмжээтэй болгосныг үндэслэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2022 оноос хойш газрын хэмжээ болон үнийн дүнг өөрчлөх хүсэлтийг хэд хэдэн удаагийн албан тоотоор хүргүүлсэн боловч шийдвэрлээгүй байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	42,922,123.65	34,745,626.18
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,000,000.00	3,000,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,000,000.00	3,000,000.00
3121	Төгрөг	4,000,000.00	3,000,000.00
31211	Төрийн сангийн харилцах	1,000,000.00	00.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	3,000,000.00	3,000,000.00
33	АВЛАГА	11,211,562.65	1,382,245.18
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	11,211,562.65	382,245.18
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	1,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	27,710,561.00	30,363,381.00
354	Хангамжийн материал	27,710,561.00	30,363,381.00
35410	Бичиг хэргийн материал	5,716,862.00	2,889,402.00
35420	Аж ахуйн материал	20,144,699.00	23,373,799.00
35440	Түлш, шатах тослох материал	814,000.00	2,990,180.00
35470	Бусад хангамжийн материал	1,035,000.00	1,110,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	843,337,701.69	922,452,154.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	843,337,701.69	922,452,154.34
392	Биет хөрөнгө	780,116,701.86	859,656,154.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	757,438,769.19	757,438,769.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	(183,147,606.65)	(212,905,440.05)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	90,000,000.00	90,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(45,016,666.67)	(55,383,333.51)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	227,305,339.04	285,127,808.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	(112,904,247.67)	(143,371,342.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	95,753,695.16	201,453,711.15
39208	Хуримтлагдсан элэгдэл	(52,498,580.54)	(65,890,018.48)
39214	Бусад үндсэн хөрөнгө	189,400.00	189,400.00
39217	Ном	2,996,600.00	2,996,600.00
393	Биет бус хөрөнгө	63,220,999.83	62,796,000.08
39301	Програм хангамж	1,550,000.00	1,550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(850,000.17)	(1,274,999.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	62,521,000.00	62,521,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	886,259,825.34	957,197,780.52
413	Өглөг	39,619,081.93	21,946,856.07
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	36,619,081.93	15,443,706.07
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	2,699,750.00
4136	Бусад өглөг	3,000,000.00	3,803,400.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	3,000,000.00	3,803,400.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	846,640,743.41	935,250,924.45
51	Засгийн газрын хувь оролцоо	846,640,743.41	935,250,924.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	818,720,719.00	818,720,719.00
51101	Өмч: - төрийн	818,720,719.00	818,720,719.00
512	Хуримтлагдсан үр дүн	(10,692,166.35)	77,918,014.69
51210	Өмнөх үеийн үр дүн	(10,692,166.35)	(10,692,166.35)
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	88,610,181.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	38,612,190.76	38,612,190.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	886,259,825.34	957,197,780.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,605,941,453.68	3,461,369,685.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	68,293,053.68	158,661,485.59
120	Нийтлэг татварын бус орлого	68,293,053.68	158,661,485.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	44,771,053.68	158,661,485.59
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого\Үндсэн хөрөнгө\	41,657,453.68	158,511,458.59
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого\Бараа материал\	3,113,600.00	150,000.00
120009	Бусад орлого	23,522,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,537,648,400.00	3,302,708,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,529,773,600.00	3,247,963,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,529,773,600.00	3,247,963,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,874,800.00	54,744,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	54,604,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,874,800.00	140,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,643,710,984.95	3,372,759,504.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,643,710,984.95	3,372,759,504.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,151,455,110.68	2,996,642,946.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,610,138,365.72	2,404,161,174.37
210101	Үндсэн цалин	954,318,620.96	1,515,055,422.00
210102	Нэмэгдэл	444,907,409.12	585,800,183.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	109,725,000.00	118,425,684.00
210104	Урамшуулал	101,187,335.64	184,879,884.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	202,840,418.32	300,289,400.01
210201	Тэтгэврийн даатгал	137,562,402.89	203,077,728.01
210202	Тэтгэмжийн даатгал	16,564,562.49	24,175,143.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,450,761.48	12,111,071.50
210204	Ажилгүйдлийн даатгал	8,052,538.38	12,111,071.50
210205	Эрүүл мэндийн даатгал	32,210,153.08	48,814,386.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,093,628.49	106,586,155.81
210301	Гэрэл, цахилгаан	6,851,732.09	8,570,511.41
210302	Түлш, халаалт	91,582,632.40	94,395,324.40
210303	Цэвэр, бохир ус	2,659,264.00	3,620,320.00
2104	Хангамж, бараа материалын зардал	83,201,138.53	71,849,253.41
210401	Бичиг хэрэг	31,732,207.50	28,583,960.00
210402	Тээвэр, шатахуун	19,057,898.00	12,473,820.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,537,015.03	19,368,423.41
210404	Ном, хэвлэл	840,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,245,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,834,018.00	10,178,050.00
2105	Нормативт зардал	223,800.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	223,800.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,711,030.00	10,065,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	661,000.00	00.00
210604	Урсгал засвар	32,050,030.00	10,065,350.00
2107	Томиллолт, зочны зардал	16,409,000.00	9,023,500.00
210702	Дотоод албан томиллолт	16,409,000.00	9,023,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,338,869.00	6,091,580.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,902,261.00	980,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	490,000.00	490,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,684,900.00	3,800,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	85,980.00	83,880.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,864,000.00	737,000.00
210807	Газрын төлбөр	289,728.00	00.00



Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,498,860.62	88,576,532.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	4,168,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	88,498,860.62	84,408,032.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	492,255,874.27	376,116,558.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	207,999,916.96	276,737,279.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	113,792,000.00	258,037,279.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	84,437,916.96	17,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,770,000.00	1,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	284,255,957.31	99,379,279.01
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	284,255,957.31	99,379,279.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(37,769,531.27)	88,610,181.04
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(37,769,531.27)	88,610,181.04

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,540,648,400.00	3,302,708,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,000,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,000,000.00	00.00
120009	Бусад орлого	3,000,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,537,648,400.00	3,302,708,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,529,773,600.00	3,247,963,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,529,773,600.00	3,247,963,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,874,800.00	54,744,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	54,604,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,874,800.00	140,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,530,623,600.00	3,298,697,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,530,623,600.00	3,298,697,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,045,156,517.43	2,921,580,641.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,621,620,665.12	2,408,481,632.77
210101	Үндсэн цалин	965,800,921.06	1,519,108,224.40
210102	Нэмэгдэл	444,907,409.12	585,800,183.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	109,725,000.00	118,693,340.00
210104	Урамшуулал	101,187,334.94	184,879,884.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	174,285,611.29	306,315,000.00
210201	Тэтгэврийн даатгал	118,122,184.04	209,103,328.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,194,388.98	24,175,143.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,276,719.36	12,111,071.50
210204	Ажилгүйдлийн даатгал	6,938,463.85	12,111,071.50
210205	Эрүүл мэндийн даатгал	27,753,855.06	48,814,386.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,093,628.49	106,553,155.81
210301	Гэрэл, цахилгаан	6,851,732.09	8,570,511.41
210302	Түлш, халаалт	91,582,632.40	94,362,324.40
210303	Цэвэр, бохир ус	2,659,264.00	3,620,320.00
2104	Хангамж, бараа материалын зардал	72,240,583.53	67,638,323.41
210401	Бичиг хэрэг	27,243,790.00	21,159,750.00
210402	Тээвэр, шатахуун	18,600,000.00	14,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,727,272.53	20,243,423.41
210404	Ном, хэвлэл	1,176,000.00	1,120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,245,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,293,521.00	9,070,150.00
2105	Нормативт зардал	765,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	765,000.00	00.00



Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,443,960.00	13,308,950.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,445,500.00	2,865,000.00
210604	Урсгал засвар	35,998,460.00	10,443,950.00
2107	Томилолт, зочны зардал	16,409,000.00	11,423,500.00
210702	Дотоод албан томилолт	16,409,000.00	11,423,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,298,069.00	6,091,580.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,861,461.00	980,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	490,000.00	490,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,684,900.00	3,800,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	85,980.00	83,880.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,864,000.00	737,000.00
210807	Газрын төлбөр	289,728.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,768,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,768,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	485,467,082.57	377,116,558.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	201,211,125.26	276,737,279.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	113,792,000.00	258,037,279.00
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	75,994,125.26	17,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,425,000.00	1,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	284,255,957.31	100,379,279.01
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	284,255,957.31	100,379,279.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,024,800.00	4,011,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	16,524,800.00	5,011,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,524,800.00	5,011,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	16,524,800.00	5,011,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,524,800.00	5,011,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(16,524,800.00)	(5,011,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(6,500,000.00)	(1,000,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,500,000.00	4,000,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,000,000.00	3,000,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	27,077,364.92	884,410,274.68
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	27,077,364.92	884,410,274.68
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(37,769,531.27)	(37,769,531.27)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	(10,692,166.35)	846,640,743.41
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	(10,692,166.35)	846,640,743.41
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	(10,692,166.35)	846,640,743.41
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	88,610,181.04	88,610,181.04
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	77,918,014.69	935,250,924.45

Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,333,991,200.00	3,149,320,395.99	184,670,804.01	94.46
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,333,991,200.00	3,149,320,395.99	184,670,804.01	94.46
Улсын төсвөөс санхүүжих	3,333,991,200.00	3,149,320,395.99	184,670,804.01	94.46
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,333,991,200.00	3,149,320,395.99	184,670,804.01	94.46
УРСГАЛ ЗАРДАЛ	3,333,991,200.00	3,149,320,395.99	184,670,804.01	94.46
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,053,591,200.00	2,872,583,116.99	181,008,083.01	94.07
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,450,520,500.00	2,359,473,107.77	91,047,392.23	96.28
Үндсэн цалин	1,378,659,500.00	1,519,108,224.40	(140,448,724.40)	110.19
Нэмэгдэл	643,624,200.00	536,791,658.87	106,832,541.13	83.40
Унаа хоолны хөнгөлөлт	160,948,300.00	118,693,340.00	42,254,960.00	73.75
Урамшуулал	267,288,500.00	184,879,884.50	82,408,615.50	69.17
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	306,315,000.00	306,315,000.00	00.00	100.00
Тэтгэврийн даатгал	211,136,500.00	209,103,328.00	2,033,172.00	99.04
Тэтгэмжийн даатгал	23,794,600.00	24,175,143.00	(380,543.00)	101.60
ҮОМШӨ-ний даатгал	11,897,300.00	12,111,071.50	(213,771.50)	101.80
Ажилгүйдлийн даатгал	11,897,300.00	12,111,071.50	(213,771.50)	101.80
Эрүүл мэндийн даатгал	47,589,300.00	48,814,386.00	(1,225,086.00)	102.57
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,906,900.00	106,553,155.81	12,353,744.19	89.61
Гэрэл, цахилгаан	9,974,800.00	8,570,511.41	1,404,288.59	85.92
Түлш, халаалт	103,948,100.00	94,362,324.40	9,585,775.60	90.78
Цэвэр, бохир ус	4,984,000.00	3,620,320.00	1,363,680.00	72.64
Хангамж, бараа материалын зардал	84,596,400.00	67,638,323.41	16,958,076.59	79.95
Бичиг хэрэг	29,925,000.00	21,159,750.00	8,765,250.00	70.71
Тээвэр, шатахуун	26,513,600.00	14,800,000.00	11,713,600.00	55.82
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,891,600.00	20,243,423.41	(3,351,823.41)	119.84
Ном, хэвлэл	700,000.00	1,120,000.00	(420,000.00)	160.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,496,000.00	1,245,000.00	251,000.00	83.22
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,070,200.00	9,070,150.00	50.00	100.00
Нормативт зардал	1,493,700.00	00.00	1,493,700.00	00.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,493,700.00	00.00	1,493,700.00	00.00
Эд хогшил, урсгал засварын зардал	52,030,800.00	13,319,950.00	38,710,850.00	25.60
Багаж, техник, хэрэгсэл	6,200,700.00	2,876,000.00	3,324,700.00	46.38
Тавилга	20,000,000.00	00.00	20,000,000.00	00.00
Урсгал засвар	25,830,100.00	10,443,950.00	15,386,150.00	40.43
Томилолт, зочны зардал	26,333,900.00	11,423,500.00	14,910,400.00	43.38
Дотоод албан томилолт	26,333,900.00	11,423,500.00	14,910,400.00	43.38
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,490,000.00	6,091,580.00	5,398,420.00	53.02
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,800,000.00	980,700.00	2,819,300.00	25.81
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	490,000.00	10,000.00	98.00
Даатгалын үйлчилгээ	3,800,000.00	3,800,000.00	00.00	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	398,100.00	83,880.00	314,220.00	21.07
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,491,900.00	737,000.00	1,754,900.00	29.58
Газрын төлбөр	500,000.00	00.00	500,000.00	00.00
Бараа үйлчилгээний бусад зардал	1,904,000.00	1,768,500.00	135,500.00	92.88

Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан				
Барaa үйлчилгээний бусад зардал	1,904,000.00	1,768,500.00	135,500.00	92.88
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	280,400,000.00	276,737,279.00	3,662,721.00	98.69
Бусад урсгал шилжүүлэг	280,400,000.00	276,737,279.00	3,662,721.00	98.69
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	260,000,000.00	258,037,279.00	1,962,721.00	99.25
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,400,000.00	17,400,000.00	00.00	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	1,300,000.00	1,700,000.00	43.33
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	4,000,000.00	(4,000,000.00)	00.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	3,000,000.00	(3,000,000.00)	00.00
АЖИЛЛАГСДЫН ТОО	38	37	1	97.37
Удирдах ажилтан	5	5	0	100.00
Гүйцэтгэх ажилтан	29	28	1	96.55
Үйлчлэх ажилтан	4	4	0	100.00
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	38	37	1	97.37
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	18	17	1	94.44
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	9	9	0	100.00
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	11	0	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	54,008,525.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	54,008,525.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,008,525.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	49,008,525.00
210102	Нэмэгдэл	49,008,525.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	54,008,525.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	54,008,525.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,008,525.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газар нь эрхэм зорилгоо Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтооно. Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндсэн хуульд байгууллагыг хамгаалах хууль дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, иргэний эрх зүйн ухамсар, соёлыг дээшлүүлэх, гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож болохгүй" гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллага нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, анхан болон давж заалдах шатны Шүүхийн Тамгын газрын 2024 оны "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө: 4.1.3-д "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 957,197.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 70,938.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	42,922.1	34,745.6	(8,176.5)
Мөнгөн хөрөнгө	4,000.0	3,000.0	(1,000.0)
Авлага	11,211.6	1,382.2	(9,829.3)
Бараа материал	27,710.6	30,363.4	2,652.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	843,337.7	922,452.2	79,114.5
Үндсэн хөрөнгө	1,237,754.8	1,401,277.3	163,522.5
Хуримтлагдсан элэгдэл	(394,417.10)	(478,825.13)	(84,408.0)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	886,259.8	957,197.8	70,938.0
Өр төлбөр	39,619.1	21,946.9	(17,672.2)
Засгийн газрын хувь оролцоо	846,640.7	935,250.9	88,610.2

Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	886,259.8	957,197.8	70,938.0

Мөнгөн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 3,000.0 мянган төгрөг нь шүүхийн барьцаа хөрөнгийн дансны үлдэгдэл, ахмадын сангийн харилцах дансны зарцуулаагүй үлдэгдэл 1,000.0 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлснийг татаас санхүүжилтийн авлагаар тусгасан байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 11,211.6 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлагын суутган тооцож барагдуулан, ажиллагсадтай холбоотой ээлжийн амралтын цалинг урьдчилж олгосон 382.2 мянга, ахмадын сангийн 1,000.0 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 30,363.4 мянган төгрөг болж, 2,652.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 64,082.0 мянган төгрөгөөр, шилжүүлэн авсан 150.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 61,579.2 мянган төгрөгөөр зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,401,277.3 мянган төгрөг болж, 163,522.5 мянган төгрөг болж нэмэгдсэн нь аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс 5,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг нэмэлт санхүүжилтээр, төсвийн хөрөнгөөр 231.0 мянган төгрөгийн утаа мэдрэгчтэй камер худалдан авч, Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс 52,811.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 105,700.0 мянган төгрөгийн тавилга, Монгол Улсын Дээд шүүхээс 1,792.0 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, Сэлэнгэ аймгийн Шүүхийн Тамгын газраас 2,012.0 мянган төгрөгийн үнэтэй зөөврийн компьютерыг тус тус үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 21,946.9 мянган төгрөг нь төсвийн зарцуулах эрх нээгдээгүйгээс шалтгаалан ажилчидтай холбогдсон нийгмийн даатгалын шимтгэлийн 8,364.7 мянга, ХАОАТ-ын 6,696.7 мянга, урсгал засварын материалын 803.4 мянга, бичиг хэргийн материалын 2,699.7 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 935,250.9 мянган төгрөг болж 88,610.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 88,610.2 мянган төгрөгтэй холбоотой байна.

Тус байгууллага нь 2010 оноос хойш “Санхүүгийн тооцоолох” ХХК-ны 550.0 мянган төгрөгийн Acolous санхүүгийн программ хангамж, 2017 оноос хойш 275.0 мянган төгрөгийн нярвын программыг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

БНА-2026/119/НА-СТА-ТШЗ



Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,439,300.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,436,300.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 105,308.8 мянган төгрөгөөр бууруулж 3,333,991.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 3,333,991.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3,247,963.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, 86,027.8 мянган төгрөгийн дутуу олгогдсон байна. Гүйцэтгэлээр 3,149,320.4 мянган төгрөгийг зарцуулж, 99,379.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,149,320.4 мянган төгрөг буюу 94.5 хувьтай байгаа нь байр цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 91,047.4 мянга, хангамж бараа материалын зардал 16,958.1 мянга, нормативд зардал 1,493.7 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 38,710.9 мянга, дотоод албан томилолтын зардал 14,910.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 5,398.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 135.5 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	3,049,791.2	2,871,602.4	178,188.8	94.16
2	80224 Зөвлөл, хороо, комиссын гишүүд	1,000.0	480.7	519.3	48.07
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	280,400.0	276,737.3	3,662.7	98.69
4	81569 Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	1,500.0	500.0	1,000.0	33.33
5	82322 Гэрчийн зардал	1,300.0	0.0	1,300.0	-
	Нийт дүн	3,333,991.2	3,149,320.4	184,670.8	94.46

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Бүтэц орон тоог Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар удирдах 5, гүйцэтгэх 29, үйлчлэх 4 албан тушаалтны орон тоог баталсан бөгөөд төсвийн тодотголоор орон тоо хасаагүй, гүйцэтгэлээр 37 орон тоотой 2,359,473.1 мянган төгрөгийн цалингийн сантай, 1 орон тоо дутуу ажилласан байна.

Тус байгууллагын хоол, унааны зардалд 160,948.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас, гүйцэтгэлээр нэг өдрийн 15.0 мянган төгрөгөөр тооцон 118,693.3 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлт олгосон байна.

Тайлант онд сургалт семинар зөвлөгөөнд зарцуулахаар 1 арга хэмжээний 8,504.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1 арга хэмжээнд 6,452.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 54,604.8 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 140.0 мянган төгрөгийн орлогоос 54,008.5 мянган төгрөгийг орон нутгийн нэмэгдэл, эд хогшил, урсгал засварын зардалд зарцуулж, үлдэгдэл 736.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газар нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхзул гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 49 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Тус байгууллагын даргын албан үүргийг 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн Г.Мөнгөнцэцэг түр орлон гүйцэтгэж, 2025 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг дарга М.Майжаргал зурж, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Мөнхзул нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн

Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан
гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны жилийн батлагдсан төсөвт зардал 3,333,991.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 33,339.9 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 65 хувиар буюу 21,670.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд тогтмол зардлыг 100 хувь зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2025 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 166 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан бөгөөд 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 3,294,268.1 мянган төгрөгийн 21 гүйлгээ цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 459,998.1 мянган төгрөгийн 11 гүйлгээг мэдээлэхээс 96,679.9 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийн гүйлгээг аудитын явцад нөхөн мэдээлэв. Гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 138,183.8 мянган төгрөгийн 51 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхзул гүйцэтгэж, аудитаар 36,619.1 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Ренаулт Дастер маркийн автомашин нь 2022 оны 02 дугаар сарын 02-ны өдөр авто осолд орж, аймгийн Авто тээврийн үндэсний төвийн инженерийн хохирлын дүгнэлтийг үндэслэн хэрэг бүртгэл нээн шийдвэрлүүлж хохирлын үнэлгээг төлж барагдуулсан учир актлуулах, мөн Хундай Сонота-6 автомашиныг ХУД-ийн Шүүхийн Тамгын газраас 2018 оны 06 дугаар сард балансаас балансад шилжүүлэн авсан ба байгууллагын техникийн комисс болон Өмч хамгаалах байнгын зөвлөлөөс дүгнэлт гаргаж актлуулахаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 322 дугаар албан бичгээр хүсэлт тус тус хүргүүлсэн. Дараагийн тайлангийн аудитаар ТӨБЗГ-ийн шийдвэрээр дээр автотээврийн хэрэгслийг хэрхэн шийдвэрлэснийг үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----